



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

Мал, амьтны гоц халдварт шүлхий
өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/399 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1362 дугаар захирамж, нийслэлийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/102 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг дүүргийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор шуурхай зохион байгуулсугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус өвчинд мэдрэмтгий нийт 3100 толгой мал, амьтныг бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ" трейд ХХК (А.Цэрэндагва)-д, вакцинжуулалт хийгдэх товлосон хугацаанд малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур, халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тослох материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4.Гоц халдварт өвчний дархлаажуулалтад шаардагдах 2,086,800 (Хоёр сая наян зургаан мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Дархлаажуулалтын арга хэмжээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны ... дүгээр сарын ... ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН
АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	200	2410	482,000
2	Тариур	ш	500	400	200,000
3	Зүү	ш	500	700	350,000
4	Нэг удаагийн маск	ш	200	200	40,000
5	Нэг удаагийн малгай	ш	200	200	40,000
6	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70,000
7	Цэнхэр спирт	л	2	6000	12,000
8	Шатахуун А-92 (вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад)	л	80	2410	192,800
ДҮН					1,386,800.00

2. Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	7	700,000.00
ДҮН						700,000.00
НИЙТ ДҮН						2,086,800.00